



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ТАЙЛАН 2012 МОНГОЛ УЛС

МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн:	Цахиагийн Элбэгдорж
Засгийн газрын тэргүүн:	Сүхбаатарын Батболд
Цаазаар авах ял:	Хэрэглэдэг
Хүн ам:	2,8 сая
Дундаж наслалт:	68,5 жил
5 доош насны хүүхдийн эндэгдэл:	1000 хүүхэд тутамд 28.8 хувь
Насанд хүрэгчдийн бичиг үсэг мэдэх явдал:	97,5 хувь

2010 онд мораториум зарласан ба цаазаар авах ялыг халах тухай асуудлаар парламент үргэлжлүүлэн хэлэлцжээ. 2009 оноос хойш цаазаар авах ял гүйцэтгээгүй. Эрүүдэн шүүх болон зүй бус харьцах үйлдэлд хариуцлага тооцохгүй байх нь өргөн тархсан. Шүүх эрх мэдлийн тогтолцоонд авилгал ердийн үзэгдэл болсон.

Үндсэн мэдээлэл

2008 оны 7-р сарын 1-нд Улаанбаатар хотноо болсон нийтийн эмх замбараагүй байдлыг тараахын тулд галт зэвсэг хэрэглэх зөвшөөрөл олгосон гэх хэрэгт буруутгагдаж байгаа цагдаагийн дөрвөн ахлах албан тушаалтны хэргийг Прокурорын газраас 2010 оны сүүлээр дахин сэргээсэн. Анхны мөрдөн байцаалтаар яллах дүгнэлт гаргаагүй аж.

2010 онд Лондонгийн Хитроу нисэх онгоцны буудалд баривчлагдсан Монгол улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын албаны дарга Батын Хурцыг 2011 оны 8-р сард Германы талд шилжүүлэн өгсөн ч, 9-р сард Герман улсын Холбооны Дээд Шүүхээс баривчлах шийдвэрийг хүчингүй болгосноор суллагдсан. Батын Хурц нь 2003 онд Франц улсын нутаг дэвсгэрт Монголын иргэн Дамирангийн Энхбатыг хулгайлсан хэрэгт сэжиглэгджээ. Батын Хурц хүн хулгайлахад оролцсон болохыг

мэдэгдсэн албан бичгийг 1-р сард Монгол Улсын эрх мэдэлтнүүдээс ХБНГУ-ын Прокурорт хүргүүлсэн тухай Их Британы Дээд Шүүхийн тогтоолд дурдсан байна. Тэрээр 9-р сард буцаж ирсэн ба сүүлд Монгол улсын Авилгатай тэмцэх газрын дэд даргаар томилогджээ.

Ял завших

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын эсрэг эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан тухай гомдлуудтай холбоотойгоор ялагдсан хэрэг бидэнд олдсон мэдээллээр алга байна. Урьд жилийн адил засгийн газар эрүүдэн шүүж, зүй бус харьцсан хэрэгт буруутгагдсан хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг мөрдөн байцааж, яллаж шийтгэсэн тухай статистик, мэдээллийг хэвлэн гаргаагүй.

Цаазаар авах ял

Цаазаар авах ял гүйцэтгээгүй. Монгол Улсын Дээд Шүүхийн мэдээлснээр цаазаар авах ял оногдуулах нь цөөрсөн байна. Ерөнхийлөгчөөс уучлал хүссэн бүх хүний цаазаар авах ялыг 30 жилийн хорих ялаар өөрчилжээ. Парламент Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай заасан Нэмэлт II Протоколыг соёрхон батлах асуудлаар санал хураалт явуулаагүй.

Эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа

Засгийн газар НҮБ-ын гэрээний байгууллагуудын гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тухай тогтоолыг баталсан. Үүнд Эрүүгийн хуульдаа нэмэлт оруулж, эрүүдэн шүүхийн тодорхойлолыг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заасантай нийцүүлэх ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө багтжээ. 2010 онд Хууль зүй, дотоод хэргийн яам Эрүүгийн

хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулсан нь бага боловч дэвшил гарсныг харуулж байна. Урьдчилан хорих 461-р анги нь 2011 оны эхээр нээгдэж, байцаалтын өрөөнд видео камер суулгасан боловч энэ төхөөрөмжийг буруугаар ашиглахаас сэргийлэх, хянах журам хамгаалалт нь хангалтгүй байна.

• 2010 оны 6-р сард Парламентын Хүний эрхийн Дэд хорооны дэргэд байгуулагдсан Ажлын хэсэг Дамирангийн Энхбат ба түүний өмгөөлөгчийг эрүүдэн шүүж, зүй бус харьцсан гэх мэдэгдлийг үргэлжлүүлэн шалгаж байна. Дамирангийн Энхбат 2003 онд Франц улсад байхдаа хулгайлагдсан ба түүнийг Монголд авчирч, нэртэй улс төрч, ардчиллын зүтгэлтэн Санжаасүрэнгийн Зоригийг хөнөөсөн хэрэгт холбогдуулан хэрэгт татсан. Хорих газарт байхдаа эрүүдэн шүүгдсэн хэмээн Дамирангийн Энхбат гомдол гаргаж байжээ. Тэрээр 2007 онд нас барсан. Түүний өмгөөлөгч Лодойсамбуугийн Санжаасүрэн(хохирогчтой холбоогүй) улсын нууц задруулсан хэрэгт буруутгагдан баривчлагдаж байжээ.

Шударга бус шүүх ажиллагаа

Хуульчид, төрийн албан хаагчдын зүгээс шүүх авилгалд идэгдэж, эрүүдэн шүүж авсан нотлох баримтад тулгуурлах зэргээр шударга бус шүүх ажиллагаа нийтлэг байгаа тухай мэдээлсэн. Шинэ байранд орсон урьдчилан хорих 461-р анги болон бусад газруудад өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрхийг баталгаажуулах нөхцөл дутагдалтай байв.

Эмнести Интернэшнлийн айлчлал/тайлан

☞ Эмнести Интернэшнлийн төлөөлөгч 10-р сард Монгол улсад айлчилсан.

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 3 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрхийн хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг

Монголын Эмнести Интернэшнл
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-44, 10 тоот Утас/Факс: 976-11-324705
aimncc@magicnet.mn
www.amnesty.mn